



ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 06 сарын 07 өдөр

Дугаар А/159

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Холбоо, навигаци ажиглалтын албаны хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэл нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны
дарга:

Д.Отгонхүү

Холбоо, навигаци, ажиглалтын
албаны Навигацийн хэсгийн
ахлагч инженер

Гишүүд:

Т.Батцэцэг

Холбоо, навигаци, ажиглалтын
албаны Санхүү, хангамжийн
хэсгийн хангамжийн мэргэжилтэн

М.Оргил

“Сэтгэл зүй судалгаа, мэдээллийн
төв” Төрийн бус байгууллагын
гишүүн (тохиролцсоноор)

Б.Мэндсайхан

“ХУД Яармаг” Төрийн бус
байгууллагын гишүүн
(тохиролцсоноор)

Нарийн бичгийн
дарга:

О.Тэмүгэ

Иргэний нисэхийн үндэсний
төвийн Хөрөнгө оруулалт,
захиалагчийн албаны Худалдан
авах ажиллагааны тасгийн
мэргэжилтэн

2. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Үнэлгээний хороо (Д.Отгонхүү)-нд, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Т.Батжаргал), Иргэний нисэхийн үндэсний төв (Н.Батсайхан)-д тус тус үүрэг болгосугай.

3. Тендер болон сонгон шалгаруулалттай холбоотой баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөх, тендер нээхэд үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг гаргуулан Дотоод аудитын албанд хүргүүлэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (О.Тэмүгэ)-д даалгасугай.

ДАРГА



С.МӨНХНАСАН